



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/1487

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уламжлалт анагаах ухааны “Бариа засал эмчилгээний заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Эрүүл яамны дэргэдэх Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Д.Цэрэндагва)-д тус тус даалгасугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах эмнэлгийн хэрэгслийг батлагдсан төсөвтөө багтаан, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д даалгасугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН

2020-A-tushaal

• 141201921

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 10
дугаар сарын 19 -ны өдрийн 1/487
дугаар тушаалын хавсралт

БАРИА ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

Нэг. Үндэслэл

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалтыг хэрэгжүүлэн Монголын уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан уламжлалт анагаах ухааны онол, эмнэл зүйн нотолгоонд суурилсан, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхэд оршино.

Бариа засал эмчилгээ нь арьсыг цоолж, гэмтээдэггүй тул өвдөхөөс болон халдвар дамжихаас сэргийлэгдсэн хүний биеийн өөрийнх нь нөхөн төлжих чадвар дээр үндэслэгдэн хийгддэг, бие организмын эд эсийг сэргээж, яс үе булчин, шөрмөсний үйл ажиллагаа, хий цусны урсгалыг сайжруулан үйлчилдэг, эмчилгээний үр дүн нь богино хугацаанд гардаг онцгой үйлчилгээтэй, гаж нөлөөгүй эмчилгээний арга юм.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1 Дарах арга- бариа заслын сувилагч өвчтөний биеийн аль нэг хэсэгт хуруу, алганы төв болон тохойн үзүүрээр дээрээс доош хөнгөнөөс хүчтэй рүү жигд уян хатан байдлаар дарахыг хэлнэ.

2.2 Илэх арга- сувилагч өвчтөний биеийн гадаргууд гарын хуруу буюу алгаараа тойруулж илэхийг хэлнэ.

2.3 Түлхэх арга- сувилагч өвчтөний биед гарын алга, гарын алганы уг, хуруугаар арьсанд өмнөөс хойш, зүүнээс баруун тийш түлхэж илэхийг хэлнэ.

2.4 Хутгах арга- сувилагч эрхий болон бусад хурууг зэрэгцүүлэн өвчтөний биеийн хэсгийн булчинг атгас хийгээд суллан тавихыг хэлнэ.

2.5 Нухлах арга- эмчлэгч гарын алга буюу шуугаар өвчтөний биеийн аль нэг хэсэгт эргэлдүүлэн нухлахыг хэлнэ.

2.6 Шүргэх арга- эмчлэгч гарын алга, алганы угаар өвчтөний аль нэг хэсгийн арьсан дээр түргэнээр ийш тийш шүргэхийг хэлнэ.

2.7 Нурууг чимхэх арга- эмчлэгч 2 гарын долоовор хурууг бага зэрэг нугалан эрхий хурууны эсрэг хандуулж, өвчтөний нурууны гол хэсгийн арьсан дээр долоовор, дунд хуруугаа өмнө талд, эрхий хуруугаа эсрэг талд нь тавиад арьсыг чимхэн доороос дээш явуулна.

2.8 Хөдөлгөх арга- эмчлэгч өвчтөний биеийн аль нэг хэсэгт үе мөчний хөдөлгөөн хязгаарлагдах байдлыг харгалзан нугалах, жийлгэх, сэгсрэх, татах мэтээр хөдөлгөхийг хэлнэ.

2.9 Тогших арга- дунд хурууны үзүүрээр аль нэг бэлчир эсвэл эмзэглэх оронд шувуу мэт тогшино. Нуруу гэх мэт биеийн гол хэсэгт хэрэглэнэ.

2.10 Алгадах арга- гарын таван хурууг дэлгэж алгаараа хэсэг газар алгадана.

2.11 Цавчих арга- алганы чигчий хурууны талаар өвчний оронд түргэн удааныг тохируулж цавчих мэт цохихыг хэлнэ.

Гурав. Бариа засал эмчилгээний ерөнхий үйлдэл

3.1 Бариа засал гэдэг нь тухайн эрхтэн системийн үйл ажиллагааг сэргээх хэвийн байдалд оруулах, засах, бие махбодийг чийрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор суваг хэрдэс болон био идэвхит сүвүүдээр хүний гар буюу өөрийн гар, багаж хэрэглэлээр биед гаднаас механик үйлчлэл үзүүлэн хийж байгаа эмчилгээний арга юм.

3.2 Бариа засал нь энерги цусны гүйдлийг тэнцвэржүүлэх, бие махбодын тамирыг сайжруулах, эрхтэн системийн үйл ажиллагааг дэмжих, хэсэг газрын хавдар, үе мөчөөр өвдөх, минчүүрэхийг дарах, булчин сулруулж, үрэвсэл дарах, өвдөлт намдаах, өвчин эсэргүүцэх буюу өвчнөөс урьдчилан сэргийлэх чадварыг нэмэгдүүлдэг.

3.3 Цусны эргэлтийн тогтолцоонд- илж нухлах засал хийж байх үед зүрх цусаа энгийн байх үеэс илүү сайн шахдаг. Артери, вен, артериолууд өргөснө, судасны цохилт түргэсэх төдийгүй шээс ялгаруулах болон бодисын солилцоо түргэсдэг.

3.4 Амьсгалын эрхтэн тогтолцоонд- мөр, нуруу, цээжинд иллэг хийх үед амьсгалыг чөлөөтэй авахуулахыг зөвлөх хэрэгтэй. Илж нухлах заслын дүнд амьсгалын замын салс ялгаруулалтыг сайжруулах болон өвчин эмгэгийн зовуурийг намдаана.

3.5 Арьс- гадар арьсанд хийлгэж байх үед хөлс ялгаралт ихэсдэг. Хөлстэй биеэр хортой бодис болон муу нөлөөтэй бодисууд гадагшилдаг.

3.6 Мэдрэлийн тогтолцоонд- мэдрэлийн тогтолцоо нь бүх биеийг жолооддог цогц үйл ажиллагаа бөгөөд засал хийснээр бүх биеийн дотор эрхтэнд нөлөөлж идэвхтэйгээр хувийн ажиллахад тусална.

3.7 Хоол боловсруулах эрхтэнд- хоол боловсруулах эрхтний өвдөлтийг багасгана.

3.8 Тунгалгийн тогтолцоонд- биеийг халдвараас хамгаалах үүрэгтэй.

3.9 Булчинд- хөшилтийг арилгаж, булчинг хэвийн байдалд оруулах.

Дөрөв. Бариа засал эмчилгээний төрөл

4.1 Илэн барих бариа- суваг хэрдэс болон сүвүүдээр хийгдэх бөгөөд тухайн цэгийн үйлчлэлээс хамаарч явагддаг бариа заслын нэг төрөл юм. Үйлчлэлээс нь хамаарч сувгийн бариа, цэгэн бариа гэж хоёр ангилна.

4.2 Даран барих бариа- цэгэн барианы нэг төрөл бөгөөд урамжлалт бариа заслын арга юм.

4.3 Эвлүүлэн барих бариа- уламжлагдаж ирсэн бариа заслын нэг төрөл.

4.4 Хийх аргаар нь:

4.4.1 Гараар хийх

4.4.2 Багаж хэрэгслээр хийх

4.5 Хэлбэрээр нь:

4.5.1 Бүх биеийн барианы хэлбэр

4.5.1.1 Бүтэн биеийн зөөлөн бариа- суваг хэрдэсийн дагууд илэх, нухах, үрэх, чичиргээж доргиох аргаар арьс арьсан доорх өөхлөг эд, булчин, шөрмөс, хөлс, тосны булчирхайд сэдээлт өгч улмаар мэдрэлийн ширхэг, бичил цусны эргэлт, тунгалгийн зангилаагаар дамжуулан тайвшруулах, цусны эргэлтийг сэргээх, арьсны тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх, булчин сулруулах, үрэвслийг дарах, өвдөлт намдаана.

4.5.1.2 Халуун тосон бариа - биеийн гадаргуугийн суваг хэрдсийн дагууд халуун тосоор илэх, нухах, үрэх аргаар бие махбодийг шимжүүлэх, захын мэдрэлийг сэргээх, үрэвслийг дарах, өвдөлт намдаана.

4.5.1.3 Сүүн болон шөлөн бариа- суваг хэрдсийн дагууд халуун сүү, шар сүү, шөл, хиймэл рашаанаар шимжүүлж илэх, нухах, үрэх аргаар бие махбодийг шимжүүлэх, дулаацуулах, хордлого тайлах, захын мэдрэлийг сэргээх, цус, тунгалгийн эргэлтийг сайжруулна.

4.5.1.4 Эмийн бодистой бариа- эмт бодис, дулааны нөлөөгөөр биеийн гадаргуун суваг хэрдсийн дагууд илэх, нухах, үрэх аргаар цусны эргэлт, тунгалгийн гүйдлийг сайжруулан, мэдрэлийг тайвшруулах, арьсны тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх, үрэвслийг намдаах, өвдөлт дарна.

4.5.1.5 Арвайтай бариа- шар усны сүвийг хаах, хөлс болон тосны булчирхайн үйл ажиллагааг зохицуулах замаар арьсны өнгөн хэсгийг шар тосонд багсарсан арвайгаар илэх, үрэх аргаар гүйцэтгэнэ.

4.5.2 Хэсэг газрын барианы хэлбэр

Хэсэг газрын бариа нь биеийн гадаргуугийн суваг хэрдэсийн дагууд нухах, дарах, илэх, үрэх аргаар сэдээлт өгөн тухайн хэсэг газрын цус, тунгалаг, хийн эргэлтийг сайжруулах, чангарсан булчинг сулруулах, өвдөлт намдаах эмчилгээний арга юм.

4.5.2.1 Толгой, хүзүү, нуруу

4.5.2.2 Нүүрний хэсэг

4.5.2.3 Гарын /мөр, бугалга, шуу, тохой, сарвууны хэсэг/

4.5.2.4 Сээр, ууц нуруу, бүсэлхий

4.5.2.5 Хөлийн /түнх, гуя, өвдөг, шилбэ, тавхайн хэсэг/

4.5.2.6 4 тольтын бариа

4.5.2.7 Бусад

Тав. Бариа засал эмчилгээ

5.1 Заалт: зөөлөн эдийн гэмтэл, булчин, шөрмөс зангирах, хүзүү, мөрний өвдөлт, саа, саажилт, тулай өвчин, шингээлт муудах, өтгөн хатах, дуршил хаагдах, цусны даралт ихсэх, цусны даралт багасах, арьс хуурайших, хэсэг газар хүйт оргих, сарын хир өвдөлттэй ирэх, хүүхэн хэвтэш доошилсон, эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн болон хий бүрэлдсэн өвчин, хүүхдийн уушгины өвчин, суулгалт, цагаан судасны өвчин таван эрхтэний өвчин, нойргүйдэх, ядрах

5.2 Эсрэг заалт: хорт хавдар, ясны хугарал, үений хурц үрэвсэл, багана нурууны сүрьеэ, ясны сийрэгжилт, нугас дарагдсан ба нугалам хоорондын эвэрхий, хоол

боловсруулах эрхтэний хурц үрэвсэл, зүрхний шигдээс, жирэмсэн эмэгтэйчүүд, сэтгэцийн эмгэг, тамир тэнхээ дорой хүн

Зургаа. Бариа засал эмчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага

6.1 Монгол Улсад мөрдөгдөж буй эрүүл мэндийн холбогдолтой хууль тогтоомж, тушаал, журам заавар, холбогдох стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж, хүн амд чанартай тусламж үйлчилгээ үзүүлнэ.

6.2 Бариа засал эмчилгээг уламжлалт анагаах ухааны тусламж үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд

6.3 Бариа засал эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь амбулаториор, өдрийн, хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр үзүүлнэ.

Долоо. Бариа засал эмчилгээг хийхэд шаардлагатай зүйлс, орчин нөхцөл

7.1 Бариа засал эмчилгээг үзүүлэхэд шаардлагатай өрөө, тасалгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг холбогдох стандартад заасны дагуу бүрдүүлэн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх нөхцөлөөр хангана.

7.2 Бариа хийх тасалгаа цэвэр, агааржуулалт сайтай, дулаан, дуу чимээ багатай, өрөөний талбай 18м^2 , дулаан $20\text{-}22^{\circ}\text{C}$ байна. Өрөөнд гар угаалтуур, бариа заслын зориулалтын ор, сандал, зориулалтын ивээс болон дэвсгэр даавуу, биеийн алчуур, гар нүүрний алчуур, цаасан алчуур зэрэг байна.

7.3 Өрөөнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх эмийн сан байх шаардлагатай. Үүнд: Даралтны аппарат чагнуур, пульсоксиметр, хөвөн, бинт, спирт, иод, метилен, наалт, хайч, гэх мэт зүйл байна.

7.4 Бариа шар тос, чөмөгний тос, ургамлын тос, оливын тос төрөл бүрийн ургамлын ханд, амин дэмтэй тос хэрэглэнэ.

Найм. Бариа засал эмчилгээг хийх үйлдлийн дараалал

8.1 Эмчлүүлэгчийг тохиромжтой байрлалд хэвтүүлнэ.

8.2 Эмчийн зааврын дагуу бэлдсэн цэвэр тос буюу эмтэй тосыг нимгэн биед шингээж түрхэнэ.

8.3 Эхлээд гарын хуруунаас мөрний үе хүртэл, хөлийн урд хэсэгт хурууны үзүүрээс цавь хүртэл тасралтгүй жигд илэх аргаар эмчлүүлэгчийг тайвширтал түрхэнэ, дараа нь нухах, үрэх, гуяны булчинд цавчих, цохих, алгадах зэрэг чичиргэж доргиох аргаар цочроогоод ахин илж тайвшруулан амраах зэргээр 10 минут барина.

8.4 Хэвлийн хэсэгт нар зөв тойруулах, баруунаас зүүн тийш нь хөндлөн иллэг, аюулхайгаас доош нь шулуун иллэгийг 5-7 минут гүйцэтгэнэ. Цээжинд зүүнээс баруун тийш, баруунаас зүүн тийш хөндлөн, цээжний голоос хоёр тийш дугуй, ороомог, долгион хэлбэрийн иллэгийг 5-7 минут гүйцэтгэнэ.

8.5 Эмчлүүлэгчийг доош харуулан хэвтүүлээд хөлийн ар болон өгзөгт илэх аргаар тайвшруулах, нухах, үрэх, цавчих, цохих, алгадах зэрэг доргиох, ахин тайвшруулах аргаар 10 минут, нурууны булчинд хөндлөн, тууш илэх, нухах, хавирганы хэсэгт самчилж илэх, нурууны дээд болон далны булчин, мөрний хэсэгт илэх, хөндлөн болон тууш нухах, цавчих, цохих, алгадах, илүүрдэх зэргээр 15 минут барина.

8.6 Дараа нь эмчлүүлэгчийг босгож суулган эсвэл хэвтээ байрлалд нь дух, чамархай, шанаа, дагзыг илэх, нухах аргаар 10 минут, хүзүүг илэх, нухах, илүүрдэх хөдөлгөөнөөр 5 минут барина. Нийт 60-65 минут хийнэ.

8.7 Эмчлүүлэгчийг эмчилгээний дараа 3-5 минут амраана.

Ес. Бариа засал эмчилгээг хийхэд анхаарах зүйлс

9.1 Өлөн болон хэт цатгалан үед бариа эмчилгээ хийхгүй.

9.2 Цусны даралтыг эмчилгээний өмнө ба дараа тогтмол хянана.

9.3 Эмчилгээний үед дулаан хучина.

9.4 Эмчилгээний дараа 3-5 минут амраана.

9.5 Эмчилгээ хийлгэсэн өдөр бие хэл сэтгэлийн үйлийг хэтрүүлэхгүй байх.

9.6 Арьсны үрэвсэл, ил шарх, хугарч бэртсэн газар бариа хийхгүй.

Арав. Хүндрэл

10.1 Бариа заслыг хийхдээ эмчлүүлэгчийг дутуу үнэлэх, буруу байрлуулах, даралтын хүчийг тохируулаагүйгээс яс, зөөлөн эдийн гэмтэл учирна.

10.2 Бариа хийх тосыг буруу сонгосноос тухайн эмчлүүлэгчийн арьсанд тууралт, харшил үүснэ.

10.3 Бариа заслын дараа гам дэглэмийг зөвлөгөөг өгөөгүй эсвэл дутуу өгснөөр эмчлүүлэгчийн биеийн байдал хямрана.

Арван нэг. Үйлдлийг гардан гүйцэтгэгч

11.1 Уламжлалтын сувилагч, бариа заслын сувилагч

Арван хоёр. Бариа засал эмчилгээний дараах дэглэм

12.1 Бие хэл, сэтгэлийн үйлийг хэтрүүлэхгүй, даарч, жиндэхгүй, хэт халж хөлрөхгүй, ус, бороонд норохгүй, нойр хоол, ажил амралтаа зөв зохицуулах, согтууруулах ундаа, өтгөн цай, хийжүүлсэн ундаа, өөх тостой болон халуун ногоо, даршилсан хүнсний бүтээгдэхүүнийг хориглоно.

....ооо....